



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 06 дугаар сарын 03

Дугаар 01

Улаанбаатар хот

### УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН I ХУРАЛДААН

Улсын онцгой комиссын хуралдаан 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 15.00 цагт Төрийн ордон дахь Монгол Улсын Шадар сайдын хурлын өрөөнд 90.9 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Н.Номтойбаяр даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийж буй хяналт шалгалт, нөхөн сэргээлтийн ажлын талаар

*Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны  
Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв*

2. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн байгаль орчны нөхөн сэргээлт, түүнд тавьж буй хяналтын талаар

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн  
дэд сайд Б.Мөнхтамир*

3. Мал, амьтны гоц халдварт өвчний нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны  
Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн*

4. Бусад

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1.1</sup>-д заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

***Нэг. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Г.Дамдинням, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:***

1.1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах, газрын тосны бүтээгдэхүүн, шатахуун, шатах тослох материалын нийлүүлэлт, түгээлтийг тогтвортой байлгах, зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.2. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн үед алслагдсан сумдад түлш, шатахууны тасалдал үүсдэг асуудлыг судалж, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран эртнээс авч хэрэгжүүлэх;

***Хоёр. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Сандаг-Очир, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Г.Дамдинням, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Батшугар, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн А.Даваажаргал, Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал П.Одонбаатар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Ж.Болд, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Х. Батжаргал нарт:***

2.1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн байгууллага, Стандарт, хэмжил зүйн газрын хамтарсан ажлын хэсэг байгуулж улсын хэмжээнд ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд болон нөхөн сэргээлт хийлгүй орхисон газруудад нэгдсэн хяналт шалгалт хийх, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах, учирч болох эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, буруутай этгээдэд хариуцлага тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах;

2.2. Улсын хэмжээнд ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн судалгааг нарийвчлан гаргах, ашигт малтмалын хайгуулын бүсэд оршин суугаа иргэд, мал, амьтанд үзүүлж буй сөрөг нөлөөллийн судалгааг хийж Улсын онцгой комисст танилцуулах;

2.3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах;

2.4. Ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд сүүлийн 5 жилд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт, тайлан мэдээллийг Улсын онцгой комисст албан бичгээр 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх;

***Гурав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Идэрбат, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Алтангэрэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:***

3.1. Хөдөө аж ахуйн салбарын 2026-2027 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах;

3.2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах, мал, амьтны гоц халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцины нөөцийг бүрдүүлэх, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;

3.3. Зориудаар устгасан малын нөхөн төлбөрийг холбогдох акт, баримтыг үндэслэн орон нутгийн төсвөөс, шаардлагатай тохиолдолд Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх;

3.4. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний нөхцөл байдалд дүгнэлт хийж, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан бэлэн байдлыг хангах, холбогдох зардлыг урьдчилан тооцож улсын болон орон нутгийн төсөвт тусгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

***Дөрөв. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ч.Номин, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Бат-Амгалан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Э.Баттулга, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Төгсбаяр, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал, Улсын онцгой комиссын гишүүн Г.Гэрэл болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:***

4.1. Мэргэжлийн байгууллагаас гаргасан ус, цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл, усны ослоос урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг бүх төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд шуурхай тогтмол хүргэх ажлыг өргөн хүрээтэйгээр зохион байгуулах;

4.2. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулж үерийн эрсдэл бүхий газруудад айл өрх суурьшуулахгүй байх, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахыг хориглох, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийг нүүлгэн шилжүүлэх;

***Тав. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Бат-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:***

5.1. Салбарын хэмжээнд бэлтгэл, бэлэн байдлаа хангах, үерийн далан суваг, шуудууны хэвийн ашиглалтыг хангах, гарсан эвдрэл гэмтлийг засварлах, сэргээн босгох, харьяа байгууллагуудыг заавар, зөвлөмжөөр хангах, аймаг, нийслэлийн

Засаг дарга нартай хамтран тогтмол хяналт шалгалт явуулах, шаардлагатай бараа материал, хөрөнгийн нөөцийг бүрдүүлэх;

5.2. Төв, суурин газруудын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, тухай бүр Улсын онцгой комисс, Засгийн газарт тайлагнах;

***Зургаа. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, дэслэгч генерал С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Бямбасүрэн болон бүх шатны Засаг дарга нарт:***

6.1. Байгаль цаг уурын гаралтай аюулт гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд шаардлагатай бие бүрэлдэхүүн, тэдгээрийн хувцас, хэрэглэл, багаж, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, тоо хэмжээ, хүчин чадлыг тогтмол нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

6.2. Шаардлагатай тохиолдолд аймаг, сумдын Онцгой комисст дэмжлэг үзүүлж, хүн, техник хэрэгслийг тухай бүр дайчлан гаргах;

***Долоо. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Батшугарт:***

7.1. Томуу, томуу төст өвчин, улаанбурхан зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг оновчтой, үр дүнтэй, хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулах, улирлын шинж чанартай ачаалал нэмэгдэх үед салбарын бэлэн байдлыг хангах;

7.2. Хүйтний улиралд үүсэж болох эрсдэлийг урьдчилан тооцоолж, төлөвлөлтийг оновчтой болгох, нөөцийг бүрдүүлэх;

***Найм. Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Найдалаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:***

8.1. Байгаль, цаг агаарын гамшигт үзэгдэл, хүчтэй салхи шуурганы улмаас эрчим хүчний үйлдвэрлэл болон цахилгаан, дулааны шугам сүлжээний техникийн бэлэн байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, найдвартай хэвийн үйл ажиллагааг тогтмол хангаж ажиллах;

8.2. Салбарын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөт хугацаанд хийж гүйцэтгэх, өвлийн их ачааллыг давахад нэн шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;

8.3. Эрчим хүч, дулааны эх үүсвэрүүдийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах түлш, нүүрсний нөөцийг шаардлагатай хэмжээнд бүрдүүлэх, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

***Ес. Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:***

9.1. Ой, хээрийн гал түймэр, үер, усны осол, мал амьтны гоц халдварт өвчний тархалт зэрэг байгаль цаг уурын болон биологийн гаралтай аюулт, гамшигт үзэгдэл,

ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, түүний хэрэгжилтийг хангаж ажиллах;

9.2. Улсын онцгой комиссын даргын “Нэгдсэн удирдамж батлах тухай” 3 дугаар тушаалын хэрэгжилтийг бүх шатанд хангах, холбогдох төсөв, санхүүгийн эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэх;

9.3. Улсын онцгой комиссын 2026 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01, “Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 02, “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг тус тус хангаж ажиллах;

9.4. Тээврийн хэрэгслийн жолооч, малчид, иргэдэд гүүр, гарамгүй газраар гол, мөрөн гатлахгүй байх, анхаарал болгоомжтой зорчих, үер усны ослоос урьдчилан сэргийлэх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг тогтмол хүргэх;

9.5. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана, 51.2-т гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна гэж тус тус заасны дагуу 2027 оны төсөвт гамшгаас хамгаалах зардлыг тусгаж батлуулах;

9.6. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хүндрэл багатай даван туулахад шаардлагатай санхүүжилтийг энэ оны батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэх, үүсэж болох эрсдэлийг тооцож аймаг, сумдын 2027 оны төсөвт шаардлагатай хөрөнгийг тусгах;

9.7. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх, хариуцсан салбар, орон нутгийн хэмжээнд үнэлгээ хийх, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

***Арав. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян нарт:***

10.1. Улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын чадавхыг нэмэгдүүлэх ажлыг улс, орон нутгийн төсвөөс хараат бусаар өөрсдийн нөөц боломжийг ашиглан олон улсын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагатай хамтран төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төсөв санхүүгийн хувьд бие даан шийдвэрлэх боломжийг нээх эрх зүйн зохицуулалтыг Гамшгаас хамгаалах тухай хууль болон Улсын нөөцийн тухай хуульд тусгах;

10.2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд гамшгийн даатгалын тогтолцоог нэвтрүүлж, эрсдэл хуваалцах, гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд даатгалын салбарыг татан оролцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хамтарсан ажлын хэсэг гаргаж ажиллах, нэгдсэн санал, дүгнэлтийг Засгийн газраар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

**Арван нэг. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Г.Дамдинням, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Сандаг-Очир, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Батшугар, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн А.Даваажаргал, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Х. Батжаргал нарт:**

11.1. Ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг стандартын шаардлагад нийцүүлэх, байгаль орчны нөхөн сэргээлтийг холбогдох хууль, журмын дагуу хийх, оролцогч талуудыг хариуцлагажуулах, хяналт шалгалтыг үр дүнтэй хийх, салбар дундын уялдааг хангах чиглэлээр одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох, цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх нэгдсэн санал дүгнэлт боловсруулж Улсын онцгой комисс, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх;

Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг сар бүр Улсын онцгой комиссын ажлын албанд ирүүлэхийг нийт гишүүд, бүх шатны онцгой комисст, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, тухай бүр танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт тус тус даалгав.

ДАРГА

Н.НОМТОЙБАЯР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

